210402	Тээвэр, шатахуун	17,230.30	17,230.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,360.70	2,268.00
210404	Ном, хэвлэл	-	-

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88.00	65.70
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,457.00	1,301.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,457.00	1,301.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,719.00	7,149.35
210601	Багаж, техник, хэрэгсэл	100.00	-
210604	Урсгал засвар	10,619.00	7,149.35
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,656.70	1,634.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,656.70	1,634.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,008.20	1,555.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	694.20	651.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	414.30	362.20
210803	Даатгалын үйлчилгээ	90.30	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	182.90	153.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75.00	75.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	422.80	305.00
210807	Газрын төлбөр	37.30	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11.50	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	79.90	8.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	375,759.20	333,689.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	374,961.40	332,892.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	797.80	797.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,532,526.50</b>	<b>326,159.39</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	309,226.50	295,936.11
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	309,226.50	295,936.11
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,223,300.00</b>	30,223.28
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,223.30	30,223.28
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250.00	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-
220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,359,533.60</b>	<b>1,461,892.48</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,218,893.60</b>	<b>1,383,810.52</b>
132001	Орон нутгийн төсвөөс	986,733.10	1,151,650.02
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	232,160.50	232,160.50
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	140,640.00	78,081.96
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,640.00	78,081.96
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>155,283.65</b>

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>29,888.31</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>		
610001	Төсвийн байгууллага	2	2
610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>28</b>	<b>29</b>
620001	Удирдах ажилтан	11	11
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	3	5
620004	Гэрээт ажилтан	4	3
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>28</b>	<b>29</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6
650010	Гэрээт ажилтан	3	3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	10	10

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

мянган төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>120,986.28</b>	<b>5,475.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>120,986.28</b>	<b>5,475.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	75,973.63	5,475.70
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	37,622.60	-
210101	Үндсэн цалин	37,622.60	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	141.33	-
210201	Тэтгэврийн даатгал	141.33	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,557.98	-
210401	Бичиг хэрэг	925.00	-
210402	Тээвэр, шатахуун	7,678.03	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	124.95	-
210404	Ном, хэвлэл	2,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	630.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	13,121.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,943.00	-
210502	Хоол, хүнс	1,178.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,240.35	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,240.35	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	65.00	440.00
210702	Дотоод албан томилолт	65.00	440.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,225.38</b>	<b>5,035.70</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,473.50	5,035.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,751.88	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	44,800.00	-

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	44,800.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	44,800.00	
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>212.65</b>	<b>-</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	212.65	
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>120,986.28</b>	<b>5,475.70</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>120,986.28</b>	<b>5,475.70</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,791.28	3,068.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,195.00	2,406.80
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

##### ***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд “хөрөнгө оруулалтыг сумын хөгжилтэй уялдуулах замаар ард түмний санал санаачилгад тулгуурлан хэрэгжүүлснээр нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, аймгийн Загвар сум болгох” гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

*Дээрх зорилтын хүрээнд доорх дэд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.*  
Үүнд:

- I. Сумын нийгэм, эдийн засгийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын хүрэх түвшин тодорхойлох, иргэн бүр эрүүл, боловсролтой, орлоготой, амьжиргааны чадавхтай болгох.
- II. Байгалийн баялаг, түүхий эдэд тулгуурлан хөгжлийг бий болгох
- III. Ард иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжиж ажлын байр бий болгох

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

##### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Сагсай сумын Засаг дарга нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тайлант онд тус албанаас Сагсай сумын төсөвт байгууллагуудын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 11 дугаар сарын 12-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,495.7 сая төгрөгөөр буюу 53.6 хувиар буурсан байна.

*Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	377,767.1	293,725.9	(84,041.2)
Авлага	268,087.0	260,932.5	(7,154.5)
Урьдчилж гарсан зардал			-
Бараа материал	326,904.4	49,712.1	(277,192.3)
Нөөцийн бараа	-	27,261.0	27,261.0
Үндсэн хөрөнгө	9,274,585.3	4,119,963.4	(5,154,621.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>10,247,343.8</b>	<b>4,751,594.9</b>	<b>(5,495,748.9)</b>
Өр төлбөр	15,172.8	5,870.2	(9,302.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,232,171.0	4,745,724.7	(5,486,446.3)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>10,247,343.8</b>	<b>4,751,594.9</b>	<b>(5,495,748.9)</b>

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Хүснэгтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, нөөцийн бараа, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө данс оны эхний үлдэгдэлтэй 84.0 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны давсан хэсгийн зарцуулалттай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 7.2 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлага 4.9 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 16.9 сая, зээлийн хүүгийн авлага 3.7 сая, бусад авлага 32.9 сая төгрөгөөр буурч, сумын Хоршоо хөгжүүлэх сангаас 51.2 сая төгрөгийн зээл олгосноор нэмэгдсэн дүнтэй байна.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа материалын данс 277.2 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө данс 5,154.6 сая төгрөгийн тус тус буурсан нь боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгөтэй холбоотой байна. Нөөцийн бараа 27.3 сая төгрөгийн нэмэгдсэн нь сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн тэжээлийн нөөц байна.

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны оны эхний 15.2 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, шинээр 5.9 сая төгрөгийн ИТХ, ЗДТГ-ын тээвэр шатахууны өглөгтэй гарсан байна.

Тайлант онд -6,056.4 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 5,486.4 сая төгрөгөөр буурсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд Сагсай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,656.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,316.9 сая төгрөгийг урсгал зардалд, 339.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,283.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 232.2 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 140.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Сагсай сум нь 2022 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,461.9 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс орон нутгийн төсвөөс 1,151.7 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 232.2 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 78.1 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвөөс 54.9 сая төгрөгийн төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс 77.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, үндсэн үйл ажиллагааны орлого /хоршоо хөгжүүлэх сан/ 62.6 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,587.3 сая төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

#### **Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 78.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. Үүний 74.9 сая төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 51 дугаар тогтоолоор Сагсай сумын 2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 402.5 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2022 оны 95 дугаар тодотголоор 460.4 сая төгрөгөөр буюу 57.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 46 дугаар хуралдааны тогтоолоор 2022 орлогын төлөвлөгөөг 460.4 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.



Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 3.1 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 2.4 сая төгрөгийн нийт 5.5 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс томилолтын зардалд 0.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 5.0 сая төгрөгийн нийтдээ 5.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 3 дүгээр сарын 02-ны өдрийн 02/98 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,781.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 47.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд дараах зардлуудыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: цалин хөлсний зардлыг 2.9 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6.4 сая, хангамж, бараа материалын зардлыг 0.1 сая, нормативт зардлыг 0.2 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 3.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.5 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 42.1 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 13.3 сая төгрөгөөр нийт 69.1 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

*Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил гараагүй байна.*

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

Тайлант онд шилэн дансны хэрэгжилтийг тус аудитын газраас 2022 оны 1-9 сарын хэрэгжилтийг шалгасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн албаны зөвлөлийн 2019.07.16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах, зөрчлийг арилгаж ажиллах талаар 1 заалттай зөвлөмж өгөгдсөний биелэгдээгүй. Учир нь дээрх 2 санг хариуцсан 1 нягтлан бодогч өмнөх онуудаас ажиллаж ирсэнтэй холбоотой зөвлөмж биелэгдээгүй байна.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт №4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					-
Албан шаардлага					
Зөвлөмж	1	0	1	0	100.00
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100.00</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Сагсай сумын Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлантай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 3 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 671.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 656.8 сая төгрөгийн залруулга хийгдэж, 0.9 сая төгрөгийн акт тогтоож, 14.1 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөн байна.

Хүснэгт №5: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сагсай сумын Засаг даргын тамгын газар	5	671,843.47	3	656,792.57	1	928.9	1	14,122.00		
2	Сагсай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Сагсай сумын ОНХСан	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Сагсай сумын Хоршоо хөгжүүлэх сан	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>		<b>5</b>	<b>671,843.47</b>	<b>3</b>	<b>656,792.57</b>	<b>1</b>	<b>928.90</b>	<b>1</b>	<b>14,122.00</b>	<b>-</b>	<b>-</b>

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

Аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

#### 1. Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

БӨА-2023/09/НА-СТА-ТТЗ

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

## 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/ Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/ Үүнээс	
							Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								